



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/27

Булган сум

“Амар тайван Булган” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV дүгээр хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Амар тайван Булган” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ч.Отгонжаргал (Аймгийн Засаг даргын Хуулийн зөвлөх)
Ж.Оюунгэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Аймгийн Цагдаагийн газрын дарга

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга: Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

2. “Амар тайван Булган” хөтөлбөрийг хууль журмын дагуу оновчтой боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж, 2025 оны I улиралд батлуулахыг ажлын хэсэг (Д.Наранбаяр)-т даалгасугай

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/27 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010129